ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Их-Уул сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/170/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn<br>Ахлах аудитор : Б.Дагвасүрэн<br>Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn<br>Аудитор П.Ганцолмон<br>Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. **Аудитын санал дүгнэлт** ........ 2
2. **Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**
   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
   2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан ........ 5
   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7
   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 8
   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
3. **Аудитын тайлан**
   3.1 Ерөнхий зүйл ........ 12
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
   3.4 Материаллаг байдал ........ 13
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 14
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
   3.8 Аудитын гол асуудал ........ 14
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж ........ 14
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15
4. **Аудитын илрүүлэлт** ........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24 № 1902/226

танай ________ -ны № ________ -т

ИХ-УУЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Т.ЖАМЪЯАНХАНД-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их-Уул сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их-Уул сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
## 2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **38,176,356.40** | **33,896,657.40** |
| **33** | **АВЛАГА** | 147,358.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 147,358.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 38,028,998.40 | 33,896,657.40 |
| **354** | **Хангамжийн материал** | 38,028,998.40 | 33,896,657.40 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 183,500.00 | 183,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 30,690,157.40 | 31,378,157.40 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 6,935,341.00 | 2,115,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 220,000.00 | 220,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,150,755,320.84** | **2,118,438,212.51** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,150,755,320.84 | 2,118,438,212.51 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,147,073,320.84 | 2,114,756,212.51 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,130,565,732.14 | 2,130,565,732.14 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (44,640,496.44) | (85,654,167.00) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 35,000,000.00 | 35,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (2,083,333.35) | (7,083,333.39) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 52,255,044.70 | 52,255,044.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (45,795,738.08) | (47,451,398.12) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17,107,954.00 | 35,057,775.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,835,993.68) | (16,433,592.37) |
| 39217 | Ном | 18,500,151.55 | 18,500,151.55 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,682,000.00 | 3,682,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,682,000.00 | 3,682,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,188,931,677.24** | **2,152,334,869.91** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,188,931,677.24** | **2,152,334,869.91** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,188,931,677.24 | 2,152,334,869.91 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 88,678,453.20 | 88,678,453.20 |
| 51101 | Өмч: - төрийн | 88,678,453.20 | 88,678,453.20 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,986,955,661.94 | 1,950,358,854.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,986,955,661.94 | 1,986,955,661.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (36,596,807.33) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 113,297,562.10 | 113,297,562.10 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,188,931,677.24** | **2,152,334,869.91** |

## 2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,172,367,517.00** | **162,261,721.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,040,245,617.00** | **17,949,821.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,040,245,617.00 | 17,949,821.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,040,245,617.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,404,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,038,841,617.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **132,121,900.00** | **144,311,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 122,075,500.00 | 143,848,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 122,075,500.00 | 143,848,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 463,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт | - | 463,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 10,046,400.00 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 10,046,400.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **183,648,069.83** | **198,858,528.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **183,648,069.83** | **198,858,528.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 183,648,069.83 | 194,266,885.33 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 82,784,793.00 | 90,663,326.00 |
| 210101 | Үндсэн цалин | 61,635,990.00 | 54,600,565.00 |
| 210102 | Нэмэгдэл | 11,300,014.00 | 25,231,314.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - |
| 210104 | Урамшуулал | - | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 9,848,789.00 | 10,831,447.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,055,629.00 | 12,563,232.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,613,557.00 | 8,771,276.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 914,535.00 | 768,492.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 694,668.00 | 973,214.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 164,330.00 | 186,386.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,668,539.00 | 1,863,864.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 41,831,659.00 | 37,948,828.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,493,859.00 | 3,853,487.00 |
| 210302 | Түлш, халаалт | 38,337,800.00 | 34,095,341.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 740,320.00 | 959,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 19,400.00 | 466,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 206,550.00 | 275,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 112,750.00 | 127,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 37,420.00 | 30,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 364,200.00 | 60,000.00 |
| **2105** | **Норматив зардал** | - | 95,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 95,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 150,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 150,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 281,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 281,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 606,000.00 | 1,337,670.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 498,000.00 | 1,216,170.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | 121,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46,629,668.83 | 50,266,929.33 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 46,629,668.83 | 50,266,929.33 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 4,591,643.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 4,591,643.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,591,643.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,988,719,447.17** | **(36,596,807.33)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,988,719,447.17** | **(36,596,807.33)** |

## 2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **88,678,453.20** | **113,297,562.10** | **1,986,955,661.94** | **2,188,931,677.24** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **88,678,453.20** | **113,297,562.10** | **1,986,955,661.94** | **2,188,931,677.24** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **88,678,453.20** | **113,297,562.10** | **1,986,955,661.94** | **2,188,931,677.24** |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **88,678,453.20** | **113,297,562.10** | **1,986,955,661.94** | **2,188,931,677.24** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **88,678,453.20** | **113,297,562.10** | **1,986,955,661.94** | **2,188,931,677.24** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (36,596,807.33) | **(36,596,807.33)** |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **88,678,453.20** | **113,297,562.10** | **1,950,358,854.61** | **2,152,334,869.91** |

## 2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **133,525,900.00** | **144,311,900.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,404,000.00** | - |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 1,404,000.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,404,000.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,404,000.00 | - |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **132,121,900.00** | **144,311,900.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 122,075,500.00 | 143,848,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 122,075,500.00 | 143,848,300.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 463,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 463,600.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 10,046,400.00 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 10,046,400.00 | - |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **133,525,900.00** | **144,311,900.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **133,525,900.00** | **144,311,900.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **133,525,900.00** | **139,720,257.00** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 82,932,151.00 | 91,346,272.00 |
| 210101 | Үндсэн цалин | 61,783,348.00 | 62,356,559.00 |
| 210102 | Нэмэгдэл | 11,300,014.00 | 23,252,764.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 9,848,789.00 | 5,736,949.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,055,629.00 | 11,732,928.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,613,557.00 | 8,078,928.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 914,535.00 | 913,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 694,668.00 | 730,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 164,330.00 | 182,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,668,539.00 | 1,827,000.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,842,100.00 | 33,128,487.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,493,859.00 | 3,853,487.00 |
| 210302 | Түлш, халаалт | 33,348,241.00 | 29,275,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 1,950,020.00 | 959,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 19,400.00 | 466,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 206,550.00 | 275,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 112,750.00 | 127,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 37,420.00 | 30,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,573,900.00 | 60,000.00 |
| 2105 | **Нормативт зардал** | - | 95,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 95,500.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 150,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 150,000.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | - | 281,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 281,700.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 746,000.00 | 2,025,670.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 638,000.00 | 1,904,170.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | 121,500.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | **4,591,643.00** |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 4,591,643.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,591,643.00 |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **128,391,989.00** | **139,356,657.00** | **(10,964,668.00)** | **109%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **128,391,989.00** | **139,356,657.00** | **(10,964,668.00)** | **109%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **128,391,989.00** | **139,356,657.00** | **(10,964,668.00)** | **109%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **77,238,789.00** | **91,346,272.00** | **(14,107,483.00)** | **118%** |
| 210101 | Үндсэн цалин | 43,879,689.00 | 62,356,559.00 | (18,476,870.00) | 142% |
| 210102 | Нэмэгдэл | 5,320,200.00 | 23,252,764.00 | (17,932,564.00) | 437% |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 28,038,900.00 | 5,736,949.00 | 22,301,951.00 | 20% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **10,965,200.00** | **11,732,928.00** | **(767,728.00)** | **107%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,716,300.00 | 8,078,928.00 | (362,628.00) | 105% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 812,200.00 | 913,500.00 | (101,300.00) | 112% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 649,800.00 | 730,800.00 | (81,000.00) | 112% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 162,400.00 | 182,700.00 | (20,300.00) | 113% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,624,500.00 | 1,827,000.00 | (202,500.00) | 112% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **36,922,100.00** | **33,128,487.00** | **3,793,613.00** | **90%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,855,000.00 | 3,853,487.00 | 1,513.00 | 100% |
| 210302 | Түлш, халаалт | 33,007,100.00 | 29,275,000.00 | 3,732,100.00 | 89% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 60,000.00 | - | 60,000.00 | 0% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **695,600.00** | **596,100.00** | **99,500.00** | **86%** |
| 210401 | Бичиг хэрэг | 63,000.00 | 103,000.00 | (40,000.00) | 163% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 277,200.00 | 275,200.00 | 2,000.00 | 99% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 235,400.00 | 127,400.00 | 108,000.00 | 54% |
| 210404 | Ном, хэвлэл | 60,000.00 | 30,500.00 | 29,500.00 | 51% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 60,000.00 | 60,000.00 | - | 100% |
| **2105** | **Норматив зардал** | **95,600.00** | **95,500.00** | **100.00** | **100%** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 95,600.00 | 95,500.00 | 100.00 | 100% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **150,000.00** | **150,000.00** | **-** | **100%** |
| 210604 | Урсгал засвар | 150,000.00 | 150,000.00 | - | 100% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **281,700.00** | **281,700.00** | **-** | **100%** |
| 210702 | Дотоод албан томилолт | 281,700.00 | 281,700.00 | - | 100% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,043,000.00** | **2,025,670.00** | **17,330.00** | **99%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,913,000.00 | 1,904,170.00 | 8,830.00 | 100% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 130,000.00 | 121,500.00 | 8,500.00 | 93% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **132,357,000.00** | **143,848,300.00** | **(11,491,300.00)** | **109%** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **132,357,000.00** | **143,848,300.00** | **(11,491,300.00)** | **109%** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 132,357,000.00 | 143,848,300.00 | (11,491,300.00) | 109% |

## 2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **363,600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **363,600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 363,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 363,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 363,600.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 463,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 463,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 463,600.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Их-Уул сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагат Их-Уул сумын Соёлын төвтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Их-Уул  сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Их-Уул сумын Соёлын төв нь Хүн амыг соён гэгээрүүлэх, хувь хүн болон бүлэг хамт олны бүтээлч чадавхи, оюун санааны илэрхийллийн таатай нөхцлийг бий болгох, хүн амд соёлын үйлчилгээг чанартай, жигд хүртээмжтэй хүргэх, бүх нийтийн соёлын боловсрол олгох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг эрхэлдэг байгууллага.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Их-Уул сумын Соёлын төвийн нь Дотоод аудитын нэгж байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их-Уул сумын Соёлын төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 500.0 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 2,172,367.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,100.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,400.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Авлага | 147.3 | - | -147.3 |
| Бараа | 38,028.9 | 33,896.6 | -4,132.3 |
| Үндсэн хөрөнгө | 2,150,755.3 | 2,118,438.2 | -32,317.1 |
| **Нийт хөрөнгө** | **2,188,931.5** | **2,152,334.8** | **-36,596.7** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,188,931.5 | 2,152,334.8 | -36,596.7 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө** | **2,188,931.5** | **2,152,334.8** | **-36,596.7** |

Авлага дансны үлдэгдэл 147.36 мянган төгрөгөөр буурсан нь авлага барагдсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 32,317.11 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 36,596.80 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 128,392.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 143,848.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 139,356.7 мянган төгрөгийг зарцуулж, 4,491.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтын орлого 463.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бичиг хэргийн зардалд 363.6 мянган төгрөгийг зарцуулан 100.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 136 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 7, хугацаа болоогүй 5 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлээгүй байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илэрсэнгүй.

**4.1 Залруулсан алдаа байхгүй.**

**4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй**

**4.3 Албан шаардлага хүргүүлээгүй.**

**4.4 Зөвлөмж өгөгдөөгүй.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Их сумын Соёлын төв | - | - | - | - | - | - | - | - | - | - |